



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн баланст бүртгэлтэй, 77,436,915.70 (далан долоон сая дөрвөн зуун гучин зургаан мянга есөн зуун арван таван төгрөг далан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад дурдсан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100599

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн
...49... дүгээр тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2022.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн агуулах, авто тавиулангийн барилга	2012	77,436,915.70	9,110,225.28	68,326,690.42	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 оны "ПАСПОРТЖУУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТ"-ээр болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй гэж дүгнэгдсэн.
НИЙТ			77,436,915.70	9,110,225.28	68,326,690.42	